

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/84/СТА-ТӨҮГ

Агуулга

| | | |
|-------|--|----|
| 1 | Аудитын гэрчилгээ..... | 3 |
| 2 | Аудитын тайлан..... | 5 |
| 2.1. | Оршил..... | 5 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 6 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 7 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 8 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 9 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 9 |
| 2.8.1 | Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл..... | 9 |
| 2.8.2 | Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал | 10 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 14 |
| 2.10. | Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 14 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл | 15 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 15 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 16 |
| 3 | Менежментийн захидал..... | 17 |
| 3.1 | Урьдчилж төлсөн татварын данстай холбоотой асуудал..... | 17 |
| 3.1.1 | Илрүүлэлт:..... | 17 |
| 3.1.2 | Эрсдэл: | 17 |
| 3.1.3 | Өгсөн зөвлөмж: | 18 |
| 3.1.4 | Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:..... | 18 |
| 3.2 | Бараа материалын данстай холбоотой асуудал..... | 18 |
| 3.2.1 | Илрүүлэлт:..... | 18 |
| 3.2.2 | Эрсдэл: | 18 |
| 3.2.3 | Өгсөн зөвлөмж: | 18 |
| 3.2.4 | Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:..... | 18 |
| 3.3 | Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал | 19 |
| 3.3.1 | Илрүүлэлт:..... | 19 |

| | | |
|-------|--|----|
| 3.3.2 | Эрсдэл: | 19 |
| 3.3.3 | Өгсөн зөвлөмж: | 19 |
| 3.3.4 | Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:..... | 19 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 20 |
| 4.4.1 | Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан..... | 20 |
| 4.2 | Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан..... | 22 |
| 4.3 | Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан | 26 |
| 4.4 | Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан | 28 |
| 5 | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 30 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ААНОАТ | Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар |
| НӨАТ | Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ү.ТӨМӨРХУЯГ
ТАНАА

2019.03.20 № 06/521
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Батлагдсан төлөвлөгөөнөөс жилийн үр дүнгийн шагналт цалинг 716.0 сая төгрөгөөр, орон тоо, цалингийн зардлыг 602.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, насжилт өндөртэй бараа материалын дүнд үнэ цэнийн бууралт тооцоогүй 271.4 сая төгрөг, худалдан авалтыг холбогдох хууль, журмын дагуу хийгээгүй 1,923.0 сая төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг, Хэмжилт, Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Гроут финанс Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/194 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн эрхэм зорилго нь:

Эх орны хөгжлийн баталгаа, Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 1983 онд байгуулагдсан бөгөөд “Эрчим хүчний тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу тус компанид Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны 49 дүгээр тогтоолоор цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, 2006 оны

106 дугаар тогтоолоор цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг олгосон. Компани нь эдгээр тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан, дулааныг үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагаа эрхэлж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг түгээх
- Цахилгаан, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг худалдах

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг зохицуулж буй дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимтой танилцахад санхүүгийн үйл ажиллагаандаа СТОУС болон Сангийн яамнаас баталсан заавар журмын хүрээнд өөрийн компанийн онцлогийг тусган боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг (цаашид НБББББ гэх) гүйцэтгэх захирлын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү НБББББ-ыг 2017 онд СТОУС болон хууль дүрмийн шинэчлэл өөрчлөлтийг тусган шинэчилсэн бөгөөд НБББББ-ийг Сангийн яам, Эрчим хүчний яамны саналыг авч, тусган удирдлагаар батлуулан мөрдөхөөр ажиллаж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн ERP програм хангамж ашигладаг байна. Энэхүү програм нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа төдийгүй худалдан авалт, төлөвлөлт, хүний нөөц, засвар, борлуулалтын модультай уялдан ажиллаж байна.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзсэн.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

Энэ нь “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагаа тогтвортой, зах зээл нь тодорхой, орлогын дүн хэлбэлзэл багатай харьцангуй хэвийн гэж үзэж сонгосонтой холбоотой юм.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны нийт орлого 253,679.4 сая төгрөг бөгөөд түүний 0.5 хувь болох 1,286.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.5 хувиар тооцсон нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 67 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 14 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хойшлогдсон татварын өр төлбөрийн дүнг алдаатай тооцсонтой холбоотой хойшлогдсон татварын өр төлбөр, хойшлогдсон татварын зардлыг 239.8 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн.

- Тайлант жилийн элэгдлийн тооцооллыг давтан хийж, илүү байгуулсан 41.6 сая төгрөгөөр элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдлийг бууруулсан.
- НББОУС 8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа"-ны 41,42 дугаар зүйлийн дагуу өмнөх тайлант үеийн алдаа болох 131.2 сая төгрөгийг хуримтлагдсан ашгийн дансанд залруулан бүртгэсэн.
- ААНОАТ-ын тухай хуулийн дагуу орлогын албан татварын тооцооллыг хийж компанийн бүртгэсэн татварын зардалтай тулган шалгаж, 194.2 сая төгрөгөөр орлогын албан татварын зардал, өглөгийг нэмж бүртгэсэн болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|-----------|----------------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 3 | 677.3 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 8.1 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 6 | 4,210.9 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 10 | 4,896.3 | |

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Зардлын талаар

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 32.5.сая төгрөг, их засварын зардлаас 109.7 сая төгрөг, бараа материалын худалдан авалтаас 51.7 сая төгрөг нийт 193.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д “Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан орон тоо, зорилтот түвшиний биелэлтэд тусгагдсан ажилчдын тоог 30-н ажилтанаар нэмэгдүүлж, цалингийн зардлыг 602.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.9-д “Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Төсвийн тухай хууль болон компанийн дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

3. Компани нь тайлант жилийн үр дүнгийн шагналт цалинг батлагдсан төлөвлөгөөнөөс 716.0 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар албан шаардлага өгөв.

4. Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтнууддаа Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-ийн дагуу олгож буй 3-н сарын цалин хөлстэй тэнцэх

хэмжээний ажлаас халагдсаны тэтгэмж нь Хамтын гэрээний 12.1-ийн дагуу олгож буй тэтгэмжтэй давхцаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1 дүгээр заалтын дагуу тайлант онд 480.1 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон. Мөн хамтын гэрээний 12.1 дүгээр заалтын шаардлагыг хангаагүй ажилтанд олгосон тэтгэмж 23.6 сая төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгсөн.

5. Гүйцэтгэх захирлын 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Хөдөлмөрийн гэрээг цуцлах, ажлаас чөлөөлөх” Б/172 дугаар тушаалд Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т “Ажил олгогч нь ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа ажил хүлээлгэн өгөх хугацааг тогтоож, уг хугацааг ажлаас халах тухай шийдвэрт заана” гэсэн заалтыг тусгаж өгөөгүй гэж ажлаас чөлөөлөгдсөн Д.Ган-Эрдэнэ гомдол гаргаж түүний дагуу компаниас 6.5 сая төгрөг олгож, зориулалтын бус зардал санхүүжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Хариуцах этгээдээр төлбөрийг төлүүлэх төлбөрийн актыг тогтоосон.

6. Станц бүрэн зогссон авартай холбоотойгоор, Гүйцэтгэх захирал тушаал гарган 3-н ажилтаныг үүрэгт ажлаас нь чөлөөлж, мэргэжлийн зэргийг бууруулах шийдвэр гарсан. Гэсэн хэдий ч 2 ажилтаны цалингийн зэрэг, тарифыг бууруулаагүй цалинг хэвээр олгон 1.6 сая төгрөгийн цалин, нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Хариуцах этгээдээр төлбөрийг төлүүлэх төлбөрийн актыг тогтоосон.

7. Бараа материалын дансанд цаашид ашиглах боломжгүй 271.4 сая төгрөгийн бараа бүртгэлтэй байгаа бөгөөд энэхүү бараа материалын дүнд үнэ цэнийн бууралт тооцоогүй.

Энэ нь үнэн зөв, иж бүрэн, үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББОУС 2 "Бараа материал"-ын 9 дүгээр зүйлийн "Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: НББОУС 2 "Бараа материал"-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгсөн.

Асуудал 2: Худалдан авалтын талаар

Тайлант онд ижил төрлийн бараа материалыг салган төлөвлөж, харьцуулалтын арга хэрэглэн худалдан авсан 1,294.2 сая төгрөг, батлагдсан төсвөөс хэтрүүлж төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийсэн 230.2 сая төгрөг, тендерийн шаардлагатай материал дутуу ирүүлсэн харилцагчийг сонгон шалгаруулсан 102.6 сая төгрөг, худалдан авалтаа хийсний дараа шалгаруулалт явуулж гэрээ нөхөн байгуулсан 147.5 сая төгрөг, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг баримтлаагүй 148,5 сая төгрөг, нийт 1,923.0 сая төгрөгийн худалдан авалтыг хуулийн дагуу хийгээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1-д "Тендер оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана", 12.2-д "Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана", 12.3-д "Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2018 оны 4 дүгээр сарын 11-ний 60 дугаар тушаалаар “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн турбоагерт №1-4-ийг шинэчлэх ажлыг 2018-2019 оны их засварын хугацаанд багтаан хийж гүйцэтгэх шийдвэр гарсаны дагуу ОХУ-ын Уралын турбины заводтой 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр 79-16/215-2018/Г2018-07 тоот гэрээ байгуулагдсан. Энэхүү гэрээний дагуу тайлант онд “Дулааны дөрөвдүгээр цахилаан станц” ТӨХК нь гэрээний төлбөрийн 1-р үе шатны төлбөрийн 82 хувь буюу 17.0 сая еврог шилжүүлсэн.

Уралын турбины заводтой байгуулсан 79-16/215-2018/Г2018-07 тоот гэрээний 3.1-д “Гэрээний нийт үнэ нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, объект дээр ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн гүйцэтгэгчийн гэрээний үүргүүдийн хүрээнд гүйцэтгэгчийн авах шагнал урамшуулал зэргийг өөртөө багтаасан” гэж заасан байгаа бөгөөд гэрээний нийт үнийн дүнгээс тоног төхөөрөмж, ажил үйлчилгээний үнийг салгаж харах боломжгүй байна.

НӨАТ-ын тухай хуулийн дагуу оршин суугч бус этгээд болох Уралын турбины заводод төлж буй ажил, үйлчилгээний төлбөрөөс НӨАТ-ыг суутган төсөвт төлөх үүргийг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК нь хүлээхээр байна. Иймээс гэрээний төлбөрийн дүнг тоног төхөөрөмж, ажил үйлчилгээгээр нь салган НӨАТ-ын татвар суутган төлж буй эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн байдлын тайланд 11,117.2 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь өнгөрсөн мөн үеэс 4,704.4 сая төгрөг буюу 73.3 хувиар өссөн. Нийт авлагын 93 хувийг “Нэг худалдан авагч” бүхий загвар болох Диспетчерийн үндэсний төв ХХК-иас авах авлага эзэлж байна. Тайлант хугацааны эцэст Диспетчерийн үндэсний төв ХХК-тай авлагын үлдэгдэлийг тооцоо нийлж баталгаажуулсан байгаа хэдий ч авлагын үлдэгдэл өссөн байгаа шалтгааныг тодруулахад “Нэг худалдан авагч” бүхий загвар нь алдагдал хүлээж эхэлсэн тухай, Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгааны үнэ тарифыг өөрчлөхгүй байгаатай холбоотой гэж тайлбарлаж байсан. Цаашид “Нэг худалдан авагч” бүхий загвар алдагдал хүлээсэн хэвээр байх тохиолодолд тус компанийн дансны авлага буурахгүй, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр дутагдсан хэвээр байхаар байгаа нь дансны авлагын насжилт, бодит үнэ цэнэд нөлөөлөх эсэхийг судлаж үзэх нь зүйтэй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2018 онд 257,429.8 сая төгрөгийн орлоготой, 256,856.8 сая төгрөгийн зардалтай, 550.0 сая төгрөгийн цэвэр ашигтай, борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал 0,998 төгрөг байх зорилт тавьж ажилласан.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь 2018 онд 257,429.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 253,679.4 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Борлуулалтын орлогыг орлогын төрлөөр ангилан үзвэл цахилгаан эрчим хүч борлуулалтын орлого 204,537.5 сая төгрөг, дулааны эрчим хүч борлуулалтын орлого 40,990.9 сая төгрөг байна. Борлуулалтын орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд 10,482.5 сая төгрөг буюу 4.3 хувиар өссөн, төлөвлөгөөтэй харьцуулахад 3,750.4 сая төгрөг буюу 1.5 хувиар буурсан байна.

Тус компани нь тайлант онд 241,006.1 сая төгрөгийн борлуулалтын өртөгтэй ажилласан байгаа нь өмнөх оны дүнгээс 8,667.7 сая төгрөгөөр өссөн байгаад борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн өсөлттэй уялдсан түлшний зардлын өсөлт, ашиглалтын цахилгааны зардлын өсөлт, урсгал засварын зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна. Зардлын төрлөөр төлөвлөсөн зардалтай харьцуулан үзэхэд 7,511.4 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байгаагийн 66.6 хувь буюу 4,999.7 сая төгрөг нь үйл ажиллагааны бус зардлын хэтрэлт, 15.4 хувь буюу 1,156.3 сая төгрөг нь элэгдлийн зардлын хэтрэлт, 6.7 хувь буюу 505.4 сая төгрөг нь ашиглалтын цахилгааны зардлын хэтрэлт бусад нь найдваргүй авлагын зардал, урсгал засварын зардлын хэтрэлт байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад тус байгууллага нь өөрийн веб сайтандаа шилэн дансны /www.shilendans.gov.mn/ мэдээллийг 88 хувьтай оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 74.4 хувьтай байна.

Компанийн их засварын ажлын үед хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтанаас бусад ажилтантай батлагдсан орон тоо хэтрүүлэхгүй байх зорилгоор Хөдөлмөрийн тухай хууль зөрчин хөлсөөр ажиллах гэрээ байгуулахгүй байх гэсэн зөвлөмжийг өгсөн боловч тайлант онд батлагдсан орон тоо, цалингийн зардлыг хэтрүүлсэн хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан хэвээр байна.

Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн хяналтыг сайжруулах, гэрээ дүгнэсэн актыг үнэн зөв үйлдэж, үүргийн биелэлтийг дүгнэсний үндсэн дээр төлбөр тооцоог шилжүүлэх талаар удирдлагын зүгээс анхаарч ажиллах зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад гэрээний бүртгэлийн мэдээллийг тодорхой болгохын тулд санхүүгийн программын гэрээний модульд өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийлгэсэн хэдий ч гэрээний хугацаа хоцорсон бэлтгэн нийлүүлэгчийн гэрээний төлбөрөөс тооцох алдангийн орлого, авлагыг аккурэл сууриар бүртгэхгүй байна.

Сар бүрийн шагналт цалин олгох “Үйлдвэрлэлийн үр дүнгээр шагнал олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмжийн биелэлт 80 хувьтай байна. Тайлант жилийн байдлаар журмын төслийг боловсруулсан, захирлын зөвлөлөөр хэлэлцэгдсэн, үр дүнгийн үзүүлэлт дүгнэдэг албадууд үр дүн дүгнэх үзүүлэлтэндээ өөрчлөлт оруулах, ISO Олон улсын стандартууд болон бүтээмжийн хөтөлбөрүүд, ажлын үр дүнтэй уялдуулах, ажлын чанар, гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлтүүд, дүгнэх аргачлалаа тодорхой болгохоор ажиллаж байгаа бөгөөд тайлант онд батлагдан мөрдөгдөж эхлээгүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн заалтыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлэх, тендерийн урилгад худалдан авах бараа бүтээгдэхүүний агуулгыг ойлгомжтой байдлаар хүргэх, засварын ажлыг цаг хугацаанд баригдаж шаардлага хангаагүй оролцогчийг сонгохгүй байх, тендерийн баримт бичиг болон тендерийн өгөгдлийн хүснэгтийг алдаагүй бэлтгэх, бараа нийлүүлэх хугацааг оновчтой тогтоох зэргээр худалдан авах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурьдсан зөрчилтэй асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Урьдчилж төлсөн татварын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хойшлогдсон НӨАТ-ийн урьдчилгаа дансны үлдэгдэл жилээс жилд өсч байгаа бөгөөд энэхүү үлдэгдэлийн 554.6 сая төгрөгийн дүнд нь И-баримт авах эсэх нь бүрэн нотлогдохгүй байна.

Энэ нь оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

НӨАТ-ын авч чадаагүй тооцооны дүнгээр компанийн зардал өсч ашиг буурах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тооцоонд үлдэгдэлтэй байгаа харилцагчтай тооцоо нийлж, худалдан авалтын НӨАТ-ыг шивүүлж, НӨАТ-ын тайланд тусгах арга хэмжээ авах төдийгүй цаашид мөнгө шилжүүлсэн харилцагчдаас НӨАТ-ыг И-баримтад цаг хугацаанд нь бүртгүүлэх тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

НӨАТ-ын тооцооны үлдэгдэлтэй байгаа харилцагчтай тооцоо нийлж, худалдан авалтын НӨАТ-ыг шивүүлж, НӨАТ-ын тайланд тусгах арга хэмжээ авах төдийгүй цаашид мөнгө шилжүүлсэн харилцагчдаас НӨАТ-ыг И-баримтад цаг хугацаанд нь бүртгүүлэх тал дээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.

3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Импортоор худалдан авсан бараа материалын өртгийг гаалийн ханшаар бүртгэж байгаатай холбоотой 87.4 сая төгрөгийн ханшийн тэгшитгэлийн алдагдалыг бүртгэж тайлагнаснаар бараа материалын өртгийг уг дүнгээр дутуу бүртгэсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББОУС 21-д "Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө, СТОУС-ын хэрэглээний тайлбар 22 "Гадаад валютын гүйлгээ"-тэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материалын анхны өртөг зөрүүтэй тооцогдох

3.2.3 Өгсөн зөвлөмж:

НББОУС 21 "Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө" стандартад тодорхой бус байсан гадаад валютаар урьдчилгаа төлбөр төлөн худалдан авч буй бараа материалын худалдан авалтын өртгийг хэрхэн бүртгэхийг СТОУС-ын хэрэглээний тайлбар 22 "Гадаад валютын гүйлгээ"-д тодорхой тусгаж өгсөн ба энэхүү хэрэглээний тайлбар нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Иймээс гадаад валютаар худалдан авч буй бараа материалын анхны өртгийг тооцохдоо СТОУС-ын хэрэглээний тайлбар 22 "Гадаад валютын гүйлгээ"-г мөрдөх нь зүйтэй.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийн дагуу стандартыг мөрдөн ажиллана.

3.3 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

2017 онд их засварт ашиглахаар худалдан авч зардалд бүртгэсэн гуулин труба шаардлага хангаагүйн улмаас тухайн их засварт ашиглагдалгүй, засварын цехэд хадгалагдаж байгаа боловч бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Жинхэнэ хэрэгжилтийн” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Хөрөнгө, зардал бодитой тайлагнагдахгүй, хөрөнгө шамшигдах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалаар бүртгэж тайлагнах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 онд нийлүүлэгдэн их засвараар бүртгэсэн гуулин трубаны шаардлага хангасан трубаг бараа материалын орлогод залруулан бүртгэх арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(Төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2017 оны 12 сарын 31 | 2018 оны 12 сарын 31 |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 2,529,310,518.37 | 455,384,043.30 |
| 1.1.2 | Дансны авлага | 6,050,327,684.81 | 10,765,299,826.86 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | - | - |
| 1.1.4 | Бусад авлага | 362,564,107.60 | 351,931,671.83 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 14,166,428,656.02 | 15,564,522,480.90 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 5,377,999,036.39 | 3,564,026,868.94 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 28,486,630,003.19 | 30,701,164,891.83 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 405,456,740,010.50 | 537,391,271,802.63 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,006,867,164.91 | 48,246,388,189.24 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 2,404,570,451.54 | 52,592,384,749.36 |
| 1.2.9 | | | |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 408,868,177,626.95 | 638,230,044,741.23 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 437,354,807,630.14 | 668,931,209,633.06 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 10,855,436,870.20 | 15,092,191,179.46 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 2,245,222,646.63 | 3,585,605,617.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 160,003,612.62 | 1,984,599,109.40 |

| | | | |
|--------------|---|---------------------------|---------------------------|
| 2.1.1.4 | НДШ–ийн өглөг | 314,331,170.52 | 34,065,845.78 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 9,264,199,547.66 | 9,612,742,502.61 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 2,117,537,428.20 | 422,021,265.25 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 4,235,586,872.55 | 5,055,749,524.19 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | 530,758,676.64 | 489,118,799.48 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 4,824,991.15 | 41,233,031.05 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | | | |
| | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 29,727,901,816.17 | 36,317,326,874.22 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 85,278,736,226.64 | 128,320,705,665.34 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 3,495,272,357.59 | 2,652,290,347.31 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 9,574,519,081.15 | 10,487,200,858.09 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | Хойшлогдсон орлого | 105,832,741,495.52 | 120,212,196,159.44 |
| | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 204,181,269,160.90 | 261,672,393,030.18 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 233,909,170,977.07 | 297,989,719,904.40 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 107,919,748,900.04 | 107,919,748,900.04 |
| 2.3.2 | - хувийн | | |
| 2.3.3 | - хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 135,387,610,315.27 | 254,003,946,545.24 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | | 48,769,166,973.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (39,861,722,562.24) | (39,751,372,689.62) |
| 2.3.10 | | | |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 203,445,636,653.07 | 370,941,489,728.66 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 437,354,807,630.14 | 668,931,209,633.06 |

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

| Мөр | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|--|---------------------------|---------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 233,272,812,234.53 | 245,528,384,735.28 |
| 2 | Борлуулалтын өртөг | 232,338,443,057.41 | 241,006,110,887.92 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 934,369,177.12 | 4,522,273,847.36 |
| 4 | Түрээсийн орлого | 210,570,325.46 | 268,644,474.16 |
| 5 | Хүүгийн орлого | 142,723,366.55 | 150,323,485.76 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 7,243,644,324.20 | 7,732,025,434.93 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 1,075,137,754.51 | 1,449,197,956.45 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,050,996,189.01 | 2,502,856,147.80 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 4,020,934,226.32 | 4,566,931,482.62 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 1,477,750,736.59 | (4,209,222,740.71) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 2,861,989,760.08 | (54,941,085.37) |
| 19 | Орлогын татварын зардал | 1,516,274,431.43 | 1,528,409,113.78 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 1,345,715,328.65 | (1,583,350,199.15) |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 1,345,715,328.65 | (1,583,350,199.15) |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 23.3 | Бусад олз (гарз) | | |
| 24 | Орлогын нийт дүн | | (1,583,350,199.15) |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|--|----------------------|--|------------------------------|---------------------|----------------------|
| 1 | 2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 227,071,740,030.34 | 136,220,160,315.27 | | (42,852,327,035.54) | 320,439,573,310.07 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 812,339,144.65 | 812,339,144.65 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 227,071,740,030.34 | 136,220,160,315.27 | | (42,039,987,890.89) | 321,251,912,454.72 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | | | | 1,345,715,328.65 | 1,345,715,328.65 |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | (119,151,991,130.30) | | | | (119,151,991,130.30) |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (832,550,000.00) | | 832,550,000.00 | |
| 9 | 2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл | 107,919,748,900.04 | 135,387,610,315.27 | | (39,861,722,562.24) | 203,445,636,653.07 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | (245,584,928.24) | (245,584,928.24) |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 107,919,748,900.04 | 135,387,610,315.27 | | (40,107,307,490.47) | 203,200,051,724.84 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (1,583,350,199.15) | (1,583,350,199.15) |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 48,769,166,973.00 | | 48,769,166,973.00 |

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | | |
|----|--|--------------------|--------------------|-------------------|---------------------|--------------------|
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн өөрчлөлт | | 118,616,336,229.97 | | 1,939,285,000.00 | 120,555,621,229.97 |
| 17 | 2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл | 107,919,748,900.04 | 254,003,946,545.24 | 48,769,166,973.00 | (39,751,372,689.62) | 370,941,489,728.66 |

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 230,292,003,437.99 | 235,790,858,558.58 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 228,381,939,957.87 | 233,246,140,455.27 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | | |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | | |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 1,910,063,480.12 | 2,544,718,103.31 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 198,735,007,215.10 | 204,727,591,575.02 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 38,183,581,466.06 | 34,462,784,041.75 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 10,142,000,000.00 | 11,035,000,000.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 94,535,000,000.00 | 101,568,000,000.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | | |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 28,469,708,716.20 | 32,585,412,188.82 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | | |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 16,994,276,827.48 | 14,654,946,719.85 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | | |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 10,410,440,205.36 | 10,421,448,624.60 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 31,556,996,222.89 | 31,063,266,983.56 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 142,713,311.50 | 159,187,122.13 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | 8,863,636.37 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |

| | | | |
|------------|---|----------------------------|----------------------------|
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 142,713,311.50 | 150,323,485.76 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.1.8 | | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 24,505,177,895.20 | 77,036,326,041.33 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 24,505,177,895.20 | 28,429,191,866.32 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 48,607,134,175.01 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (24,362,464,583.70) | (76,877,138,919.20) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | - | 48,887,426,212.35 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 48,887,426,212.35 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 5,270,133,563.35 | 5,147,480,751.78 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 5,270,133,563.35 | 5,012,909,221.78 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | - | 134,571,530.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (5,270,133,563.35) | 43,739,945,460.57 |
| 4 | Валютын ханшийн зөрүү | | |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,924,398,075.84 | (2,073,926,475.07) |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 604,912,442.53 | 2,529,310,518.37 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,529,310,518.37 | 455,384,043.30 |

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|---|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | Аудитын код: |
| 2019.03,15 | | | САГ-2019/84/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК | | Сая төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|------------|---------------------------------------|---|--|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан. | 193.9 | Албан шаардлага | ХААХ-ын дарга, ТЭЗХ-ийн дарга СБХ-ийн дарга | О.Гантөмөр Ж.Отгон Д.Төмөртоогоо |
| 2 | Батлагдсан орон тоо, цалингийн зардал хэтрүүлсэн. | 602.9 | Албан шаардлага | ЗХНА-ны дарга | Ш.Туухайнжин |
| 3 | Жилийн үр дүнгийн шагналыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн олгосон. | 716.0 | Албан шаардлага | ЗХНА-ны дарга ТЭЗХ-ийн дарга | Ш.Туухайнжин Ж.Отгон |
| 4 | Ажлаас халагдсаны тэтгэмжийг давхардуулж олгосон. | 503.7 | Албан шаардлага | ЗХНА-ны дарга | Ш.Туухайнжин |
| 5 | Гүйцэтгэх захирлын тушаал буруу гарсантай холбоотой олгосон төлбөрийг зардлаар бүртгэсэн. | 6.5 | Төлбөрийн акт | ЗХНА-ны дарга СБХ-ийн дарга | Ш.Туухайнжин Д.Төмөртоогоо |
| 6 | Гүйцэтгэх захирлын тушаал биелүүлээгүй нэмэгдэл цалин олгосон. | 1.6 | Төлбөрийн акт | ЗХНА-ны дарга СБХ-ийн дарга | Ш.Туухайнжин Д.Төмөртоогоо |

| | | | | | |
|----|---|----------------|-----------------|---------------|---------------|
| 7 | Бараа материалын дүнд үнэ цэнийн бууралтыг тооцон бүртгээгүй. | 271.4 | Албан шаардлага | СБХ-ийн дарга | Д.Төмөртоогоо |
| 8 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчсөн. | 1,923.0 | Албан шаардлага | ХААХ-ын дарга | О.Гантөмөр |
| 9 | Бусад урьдчилгаа дансны үлдэгдэлд И-баримт авахгүй байх эрсдэл үүссэн. | 554.6 | Зөвлөмж | СБХ-ийн дарга | Д.Төмөртоогоо |
| 10 | Импортоор худалдан авсан бараа материалын анхны өртөг тооцолтыг стандартын дагуу хийгээгүй. | 87.4 | Зөвлөмж | СБХ-ийн дарга | Д.Төмөртоогоо |
| 11 | Ашиглагдаагүй барааг зөрүүтэй бүртгэх, бүртгэхгүй байх. | 35.3 | Зөвлөмж | СБХ-ийн дарга | Д.Төмөртоогоо |
| | Дүн | 4,896.3 | | | |

